



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 4/32

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 тоот тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх хэсэг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /НАГ-2021/14-1-ШТА-ГА/ тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2022 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны эхний хагас жилд гаргаж танилцуулахыг Аудитын гуравдугаар хэлтэс /Э.Мөнхмандах/-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хүнсний аюулгүй байдлыг хангах, хянах арга хэмжээ хангалтгүй, өнөөгийн тогтолцоо үр нөлөө багатай, үр дүнд хүрэх санхүүжилтийг бүрэн шийдвэрлэдэггүй байна.



АУДИТЫН СЭДЭВ: ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН

Улаанбаатар хот
2021 он

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

Аудитын тайланг бэлтгэсэн:

Нийслэл дэх Төрийн аудитын газар	Товчилсон үг	2-3
Аудитын 3 дугаар хэлтсийн дарга, аудитын менежер:	Э.Мөнхмандах	4
Аудитын менежер:	Б.Номинбаатар	4
Аудитор:	Г.Чулуунцэцэг	4
	Ч.Чулуун-Эрдэнэ	5-6
	М.Одгэрэл	7
	О.Дашхонгор	8-28
	Б.Золбаяр	29-31
	Бүлэг 1. Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу?	
	Бүлэг 2. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй байна уу?	
	Аудитын дүгнэлт	32
	Аудитын зөвлөмж	33
	Холбогдох байгууллагын санал	34
	Саналд өгсөн тайлбар	35

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын
Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787

Тайланг НТАГ-ын <http://www.audit.mn/>
веб сайтаас үзнэ үү.

Товчилсон үг

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ДЭМБ	Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага
ЕШ	Ерөнхий шаардлага
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МУХАҮТ	Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХХ	Монголын Хүнсчдийн холбоо
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НБОГ	Нийслэлийн Байгаль орчны газар
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
НМТГ	Нийслэлийн Мэдээлэл технологийн газар
НМЭГ	Нийслэлийн Мал эмнэлгийн газар
НОБГ	Нийслэлийн Онцгой байдлын газар
НСГ	Нийслэлийн Статистикийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
НХХААГ	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар
НХГБХГ	Нийслэлийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газар
НЦУГ	Нийслэлийн Цагдаагийн удирдах газар
НЭМГ	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
ОУБ	Олон улсын байгууллага
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕШ	Техникийн ерөнхий шаардлага
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
УИХ	Улсын Их хурал
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ХАБ	Хүнсний аюулгүй байдал
ХБТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

ХУД	Хан-Уул дүүрэг
ХҮХҮХ	Хүнс үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хэлтэс
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭЗНХҮЧ	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Хүнсний чиглэлээр нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААН-ийн тоон мэдээлэл	24-25
Хүснэгт 2	Органик хүнсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл	25
Хүснэгт 3	НХХААГ-аас хүнсний чиглэлээр зохион байгуулсан сургалт	28
Хүснэгт 4	2018-2021 оны ЭЗНХҮЧ-д тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх ТАХ-ны тоо, санхүүжигдэх дүн	29
Хүснэгт 5	2018-2021 онуудад ЭЗНХҮЧ-д тусгагдсан дүн, эхлэх хувь	30
Хүснэгт 6	Хөтөлбөрт суурилсан ТАХ-г хэрэгжүүлэхэд авсан эх үүсвэр	31
Хүснэгт 7	Нийслэлийн төсвөөс олгосон санхүүжилт	31

Графикийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	НМХГ-ын ажлын схем	16
График 2	Хоол хүнснээс шалтгаалсан хордлого	17
График 3	НМХГ-ын Төв лабораторид шинжлэгдсэн нийт сорьц 2018-2020 он	20
График 4	Лабораторийн хүчин чадал	20

Зургийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Зураг 1	НМХГ-ын Төв лабораторийн тоног төхөөрөмж	21
Зураг 2	НМХГ-ын Төв лабораторийн барилга	21
Зураг 3	Зах худалдааны төвөөс илэрсэн зөрчлийн байдал	24
Зураг 4	Органик хүнсийг баталгаажуулсан тэмдэг, тэмдэглэгээний тайлбар	26

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоол, МҮЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, НТАГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ. Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ.
Аудитын хамарсан хүрээ	Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх; Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх; Аудитад нийслэлийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, мэдээллээр хангах чиг үүрэгтэй НЗД, түүний харьяа асуудал эрхэлсэн байгууллагууд, НМХГ, төрийн өмчийн лабораториуд, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогч иргэн, хуулийн этгээд, аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулна.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн Аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим” MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, МҮЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглана.
	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитын гуравдугаар хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах, аудитын менежер Б.Номинбаатар нар хянан удирдаж, аудитор Г.Чулуунцэцэг ахлан, аудитор М.Одгэрэл, Ч.Чулуун-Эрдэнэ, О.Дашхонгор, Б.Золбаяр нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Аудитыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэв.

Аудитын явцад
үүссэн хүндрэл
бэрхшээл

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр ҮАГ-с ирсэн. 2021 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр дэд төлөвлөгөөг НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитораар батлуулж аудитыг эхлүүлсэн. Аудитын явцад багийн бүрэлдэхүүн болон шалгадагч байгууллагын ажилтнууд “Covid 19”-н халдвар, хавьталд өртсөнөөс мэдээлэл солилцох нотлох баримт цуглуулах зэрэгт хүндрэлүүд гарч байсан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хүнсний аюулгүй байдал /цаашид ХАБ гэх/-ын бодлого, эрх зүйн орчин нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт “амьд явах эрхтэй”, 16.2 дахь заалт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах”, 16.6 дахь заалт “эрүүл мэндээ хамгаалуулах” ... гэсэн суурь зарчмууд, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн актын хүрээнд бүрдэж байна.

Хүнсний тухай хуулийн 3.1.2-т “Хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байх тухай тодорхойлсон.

ХАБ-тай холбоотой хуулиуд, УИХ-ын 11, ЗГ-ын 7 тогтоол байна. Тус тогтоолуудтай уялдуулан НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүнс, хөдөө аж ахуйн салбарт суурилан 7, 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрт суурилан 15, нийт 22 дэд төсөл, хөтөлбөр зохион байгуулахаар төлөвлөжээ.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, ЭЗНХҮЧ-д УИХ, ЗГ-с батлан гаргасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр НЗДТГ-ын ХБТХ, УБЗАА-ны ХҮХҮХ-ээс дэд хөтөлбөр боловсруулан НИТХ-д өргөн барьдаг.

БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?

Ерөнхий мэдээлэл

ХАБ нь Үндэсний аюулгүй байдлын чухал хэсэг бөгөөд төрөөс баталсан хүнсний салбарын бодлого, авч буй арга хэмжээ түүний хэрэгжилт, хүнсний сүлжээний бүх үе шат дахь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, тэдгээрт тавих хяналт, шалгалт, түүнчлэн хэрэглэгчийн сэтгэл ханамжаар илэрхийлэгддэг онцлогтой.

Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулсан зөрчлийг илрүүлэхээр тандалт судалгаа, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтууд чиг үүргийн байгууллагаас хийгддэг.

ХАБ-ыг хангах асуудал нь салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд хоорондын ажлын уялдаа, хувийн хэвшлийн идэвхтэй оролцоог шаардсан салбар дундын зохицуулалтын шинжтэй, бүх нийтийг хамарсан чухал ач холбогдолтой.

1.1. Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт, арга хэмжээ болон хууль, эрх зүйн зохицуулалт үр дүнтэй, бүрэн хэрэгжсэн үү?

ХАБ-тай холбоотой хуулиуд, УИХ-ын 11, ЗГ-ын 7 тогтоол байна. Тус тогтоолуудтай уялдуулан НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүнс, хөдөө аж ахуйн салбарт суурилан 7, 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрт суурилан 15, нийт 22 дэд төсөл, хөтөлбөр зохион байгуулахаар төлөвлөжээ. Тухайлбал:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
3. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
4. “Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”
5. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” Үндэсний хөтөлбөр
6. “Сав, баглаа боодол” Үндэсний хөтөлбөр

Нийслэлийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлын талаар баримтлах хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаа нь нэгдсэн удирдлага зохицуулалтгүйгээс үр дүн, үр нөлөө муутай, бүрэн хэрэгжээгүй байна.

1.1.1. Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг хоорондын уялдаа бүрэн хангагдаж, зорилт, арга хэмжээ үр нөлөөтэй хэрэгжсэн үү?

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нийслэлийн ЭЗНХҮЧ-ийг дээрх бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хүнсний асуудал, ХАБ-г хангах 7 төсөл, хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх нийтлэг 50 арга хэмжээг дэвшүүлж, хэрэгжүүлэхээр тусгажээ.

УБЗАА-ны ХҮХҮХ, НМХГ, НХХААГ зэрэг байгууллагууд нь хүнсний бодлого хариуцсан чиг үүрэг, төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж, хүнсний сүлжээний бүх үе шатанд эрсдэлийн түвшнийг тодорхойлж, хяналт шалгалт, тандалт судалгаа, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, цаашид авах арга хэмжээний саналыг дээд шатны байгууллагуудад хүргүүлэн ажиллажээ.

Гэвч батлагдсан төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, урсгал зардал, хөрөнгө оруулалтын төсвийн саналыг тусгадаг боловч хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг НЗДТГ, НИТХ шийдвэрлэдэггүй, чиг үүргийн байгууллагууд нь өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлсээр иржээ.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт нь барилга байгууламж, авто зам зэрэг дэд бүтцэд чиглэж байгаа нь сайн хэдий ч улс үндэстний хүн амын бодлого, урт удаан оршин тогтнох гол үндэс нь эрүүл, аюулгүй, чанартай хүнсээр хангагдах, түүхий эдээс эхлэн хэрэглэгчдэд хүртэлх бүх шатны зөв мэдлэг, мэдээлэлтэй байх, хоол тэжээлтэй холбоотой аливаа өвчнөөр өвчлөх эрсдэлийг бууруулах, танин мэдэхүйн боловсролыг иргэдэд олон давтамжтай хүргэх тул цаашид ХАБ-ын асуудлыг нэн тэргүүнд анхаарах шаардлагатай байна.

Дүгнэлт: ХАБ-ыг зохицуулах бодлогын баримт бичгүүдийн уялдааг хангуулсан боловч дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт удааширч, үр нөлөөг бууруулжээ.

1.1.2. Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үндэсний стандарт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангасан уу?

Улсын хэмжээнд хүнстэй холбоотой 668 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнээс олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн 264, уялдуулсан 404 стандарт байна.

Дээрх стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтэд НМХГ хяналт тавин ажилладаг бөгөөд 2019 онд ХАБ-тай холбогдох стандарт, техникийн зохицуулалтын судалгаа хийхэд дараах үр дүн гарчээ. Үүнд:

- 150 гаруй стандартад нэмэлт өөрчлөлт оруулах;
- 100 гаруй стандартыг хүчингүй болгох;
- 50 гаруй стандартыг шинээр боловсруулах.

Тус судалгааны үр дүнгээс харвал үндэсний стандартуудын зарим нь 1970-2010 оны хооронд батлагдсан байгаа нь өнөөгийн хувьсан өөрчлөгдөж буй цаг үеийн хурдтай нийцдэггүй, байнга шинэчлэлт, өөрчлөлт хийх шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал:

- Өндөгний стандарт 1977 онд батлагдсан;
- Хүнсний ногооны стандартуудын 30 шахам хувь нь 1970-1980 онд гарсан буюу өөрчлөлт хийх шаардлагатай болсон;
- Мах, махан бүтээгдэхүүний анхан шатны бэлтгэл, боловсруулалт, тээвэрлэлт, хадгалалт, худалдаалалтыг зохицуулах техникийн баримт бичгүүд салангид стандартуудтай;
- Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд техникийн зохицуулалт хийгдэхгүй байгаа нь хяналт тавьж ажиллахад хүндрэлтэй.

НХХААГ нь газар тариалангийн үйлдвэрлэлтэй холбоотой 51 стандарт, мал аж ахуйн салбарын 84 стандартыг мөрдлөг болгон ажилладаг бөгөөд хэрэгжилтэд НМХГ-тай хамтран мониторинг хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг. Шинэчлэх шаардлагатай 8 стандартын саналыг НЗДТГ-т хүргүүлжээ. Үүнд:

1. Гахайны аж ахуйн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага, стандарт
2. Тахианы аж ахуйн үйл ажиллагааны эрүүл ахуй, ариун цэврийн журам
3. УСТ1601-83 Шар тарлан үүлдрийн үхэр. ЕШ
4. УСТ1603-83 Хар тарлан үүлдрийн үхэр. ЕШ
5. УСТ1604-83 Талын улаан үүлдрийн үхэр. ЕШ
6. MNS 4228:2003 Малын түүхий сүү. ТЕШ

7. MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ЕШ
8. MNS 5344:2011 Сүүн бүтээгдэхүүн савлах, хадгалах, тээвэрлэх журам

Мөн 2021 онд стандарт, техник зохицуулалт, норм, нормативын баримт бичигт гурил, гурилан бүтээгдэхүүний 20 үйлдвэрээс дараах 8 стандартад өөрчлөлт оруулах санал ирүүлжээ. Үүнд:

1. MNS 0461:1981 4х. Хэвийн боов. ТЕШ
2. MNS 0158:1985 4х. Жигнэмэг. ТЕШ
3. MNS 0635:1985 4х. Өрмөнцөр. ТЕШ
4. MNS 2488:1998 7х. Жигнэмэл гурилан бүтээгдэхүүн. ТЕШ
5. MNS CAC 107:2007 6х. Худалдаанд нийлүүлэх хүнсний нэмэлтийн шошгололтод тавих ерөнхий шаардлага
6. MNS 4661:2009 7х. Талх, талхан бүтээгдэхүүн. ТЕШ
7. MNS 0244:2009 Буудайн гурил. ТЕШ
8. MNS 0464:2010 12х. Бялууны төрлийн бүтээгдэхүүн. ТЕШ

Аудитын явцад шалгагдагч байгууллага болон тухайн салбарын үйл ажиллагааны тайлан мэдээ, санал, нөхцөл байдалтай танилцахад орчин үеийн хүнсний болон бэлэн бүтээгдэхүүний түүхий эд олширч тэдгээрийн физик, химийн шинж чанар өөрчлөгдсөн, техник технологийн дэвшил, өөрчлөлтөөс шалтгаалан үйлдвэрлэх, савлах, хадгалах, тээвэрлэх шатанд шинэчлэлүүд хийгдэж байгаатай холбоотойгоор өнөөгийн хэрэгцээнд нийцүүлэн зарим стандартыг сайжруулах шаардлагатай байна.

Дүгнэлт: Түүхий эд бэлэн бүтээгдэхүүний физик, химийн шинж чанарын өөрчлөлт, техник технологийн дэвшилээс шалтгаалан одоогийн мөрдөж байгаа зарим стандартууд шаардлага хангахгүй болжээ.

1.1.3. Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн үү?

ХАБ-ыг хангах зорилгоор дэвшүүлсэн дэд хөтөлбөрүүдийг чиг үүргийн байгууллага буюу НХХААГ нь хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. Үүнд:

- ❖ “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн “ХАБ-ыг хангаж, Монгол хүн эрүүл байх нөхцөлийг бүрдүүлэх” зорилгын хүрээнд 2018-2021 онд дараах ажлууд хийгдсэн. Тухайлбал:
 - Хүнсний үйлдвэрүүдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажлын хэсгийг байгуулсан.
 - Боловсруулсан шингэн сүү 2021 оны 7 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 30,726.8 мянган литр сүү үйлдвэрлэсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.5%-иар өссөн;
 - Нийслэлийн хэмжээнд нийт 1526.9 га талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл тариалахаар төлөвлөж хураасан;
 - Хотын зүүн, баруун бүсэд малын захыг мах боловсруулах үйлдвэрийн хамт байгуулах ажлыг “МБҮ Трейд” ХХК төр, хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлсэн.
- ❖ “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн “Өрхийн тариалан эрхлэгч болон хүнсний ногооны төрөлжсөн аж ахуйн нэгж, хоршоог дэмжих замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ жилийн турш тогтвортой хангах” зорилгын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Тухайлбал:
 - Хүлэмжийн тариалалт нэмэгдэж, тариалах таримлын нэр төрөл нэмэгдсэн;
 - Нийслэлийн хэмжээнд төмс, хүнсний ногооны тариалалт сайжирч, малын тэжээл 10 хувиар нэмэгдсэн;

- Хөрс цаг уурт тохирсон хүнсний ногооны төрөл нэмэгдсэн;
 - Өрхийн тариалангийн бага оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлт нэмэгдсэн;
 - ❖ “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн “Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн чацарганын тариалалтыг 10 мянган га, бусад төрлийн жимс жимсгэнийн тариалалтыг 2 мянган га талбайд хүргэж, хүн амыг экологийн цэвэр амин дэм бүхий жимс жимсгэнээр тогтвортой хангах, импортыг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулан экспортын орлогыг нэмэгдүүлэх” зорилгын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Тухайлбал:
 - Таримал жимс, жимсгэнийн талбай 0.83 га-аар нэмэгдсэн;
 - Бүлэг, хоршоо, нөхөрлөл зэрэг хамтын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн;
 - Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын чацаргана, бусад төрлийн жимс жимсгэнэ тариалах идэвх санаачилга нэмэгдсэн;
 - Цаг уурын нөхцөл байдалд дасан зохисон ургах чадвартай чацаргана бусад жимс жимсгэнийн сортын тоо нэмэгдсэн;
 - ❖ “Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих” үндэсний хөтөлбөрийн “Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчилж хөгжүүлэх, төрөлжүүлэн эрчимжүүлэх, төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, тэдгээрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах” зорилгын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Тухайлбал:
 - ЗГ-ын 2018 оны 267 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд НЗД-ын 2019 оны А/906 дугаар захирамжаар нийт 4 дүүрэгт /БЗД, НД, СХД, БХД/ хөдөө аж ахуйн тасаг шинээр байгуулагдсан;
 - НИТХ-ын 2019 оны 21/06 дугаар тогтоолын дагуу нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах ажлыг зохион байгуулсан;
 - Тэжээл дэд хөтөлбөрийн хүрээнд 2020 онд 6 дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тэжээлийн ургамал тариалах газрыг тусгаж, тэжээлийн үйлдвэрийн судалгааг мал бүхий 6 дүүргээс авсан.
 - ❖ “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн “Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэх” зорилгын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Тухайлбал:
 - СХД-ийн Бэлчээрийн менежментийн төслийн газарт 90 үхрийн зогсоол бүхий фермийн барилгыг ашиглалтад оруулжээ;
 - Малын бүртгэлийн мэдээллийн санд 33,000 гаруй малын мэдээллийг оруулсан.
- Дээрх хөтөлбөрүүдийн хэрэгжилт дунджаар 80%-тай байна. Хөтөлбөрүүд нь 2018-2023 онуудад хэрэгжиж дуусна.

НМХГ нь ХАБ-ыг хангахад чиглэсэн үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд хяналт шалгалт, тандалт судалгаа, шинжилгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр дараах ажлууд хийсэн. Тухайлбал:

- ЗГ-ын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Сав, баглаа, боодол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2018 онд тандалт судалгаа, 2019 онд удирдамжтай хяналт шалгалт хийсэн;
- ЗГ-ын 2019 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Органик болохыг илэрхийлсэн тэмдэг,

тэмдэглэгээ, мэдэгдэл бүхий дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүнд тандалт судалгааг 2019-2020 онд хийсэн;

- Шалгалтын дүн мэдээг нэгтгэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Аудитаар хүнсний салбарын үйл ажиллагаа болон хариуцсан чиг үүргүүдийн байгууллагуудын мэдээ тайлан, салбарын нөхцөл байдлаас дүгнэхэд төсөл, хөтөлбөрүүдийн уялдааг хангаж зорилго, зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж, тайлагнаж байгаа боловч хэрэгжилтийн үр дүнд сөргөөр нөлөөлж буй дараах хүчин зүйлүүд байна. Тухайлбал:

- ХАБ-ыг хангахад чиглэсэн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад санхүүжилт бүрэн шийдвэрлэгддэггүй;
- НЗДТГ-ын ХБТХ-т нийслэлийн хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичгийн уялдаа холбоог хангасан төлөвлөлтийг хийх, хэрэгжилтийг нэгтгэн зохион байгуулах хүнс, хөдөө аж ахуйн нэгж байхгүй;
- УБЗАА нь мэргэжлийн чиг үүрэг, хүний нөөцөөс бүрдсэн ХҮХҮХ-тэй боловч үйл ажиллагааны тайлан мэдээ тодорхой бус;
- Дүүргүүдийн хөдөө, аж ахуйн тасагт мэргэжлийн бус албан хаагч нар ажиллаж байна.

Үүнээс харахад ТББ, иргэн, ААН-ийн хамтын ажиллагааны үр дүнд салбарын үйл ажиллагааны хэрэгжилт хангагдаж байгаа боловч мэргэжлийн бодлого чиг үүргээр хангах, дэмжин туслах эрх үүрэг бүхий төрийн байгууллагуудын уялдаа холбоог нарийн зохицуулж өгөөгүй нь хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний үр дүнг бууруулж байгаа тул хоорондын уялдаа, хамтын ажиллагааг албажуулах шаардлагатай байна.

Дүгнэлт: Хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ ТББ, иргэн, ААН-ийн хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжжээ.

1.1.4 Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль, эрх зүйн зохицуулалт үр дүнтэй хэрэгжсэн үү?

НМХГ нь ХАБ-ын чиглэлээр Монгол Улсын хууль, ЗГ-ын тогтоол, салбарын дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, хүнсний сүлжээний үе шат бүрд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал алдагдах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах замаар ажиллаж байна. Үүнд:

- ✓ Монгол Улсын хууль – 18
- ✓ Засгийн газрын тогтоол – 31
- ✓ Захиргааны хэм хэмжээний акт /Дүрэм журам/ - 34

ХАБ-тай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зарим хуулийн заалтууд давхацсан, уялдан гарах зарим журмууд батлагдаагүй, зохицуулалт дутмаг байгаа нь хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байх шалтгаан нөхцөл болж байна. Үүнд:

- Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудын зарим заалтууд нь Эрүүл ахуйн тухай хуулийн зарим заалтуудтай давхацсан;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5³ дугаар зүйлийн 5^{3.3}¹-д заасны дагуу урьдчилан мэдэгдэж төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэж байгаа нь зөрчил дутагдал бүрэн илрэхгүй, эрсдэл нь бодитой дүгнэгдэхгүй байх;

¹ 5^{3.3}. Гүйцэтгэлийн шалгалт хийхдээ шалгуулагч этгээдэд ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

- НИТХ-ын 2014 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох тухай журам”, Худалдаа үйлчилгээний журам зэрэг нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдээгүй, эрх зүйн чадамжгүй.
- Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Үүний дагуу 2017, 2021 онуудад “Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам”-ын төсөлд саналыг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.
- Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3-т заасан үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг урамшууллын хэлбэр, тэдгээрийг олгох ЗГ-ын 2020 оны 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох” журам эцэслэн батлагдаагүй, түр журмаар зохицуулагдаж байна;
- Хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан “шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журам” батлах заалт хэрэгжээгүй;
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална” заалт хэрэгжээгүй;
- “Хүнсний зориулалтын бус хуванцар савны талаар авах арга хэмжээний тухай” ЗГ-н 2015 оны 496 дугаар тогтоол, “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” 2018 оны 189 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхэд дагалдан гарах устгах журам батлагдаагүй.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2019 оны А/113 дугаар захирамжаар Хүнсний талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд шинжилгээ хийх ажлын хэсгийг НЗДТГ, УБЗАА, НМХГ, НХХААГ, НБГ, НОБГ, НБОГ, НЭМГ, НСГ, СХЗГ, УСУГ зэрэг байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулжээ.

Ажлын хэсэг нь Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг гаргасан. Үүнд:

1. Хүнсний тухай хуулийн 42 заалтын хэрэгжилтийг тооцоход 45.0%-тай хэрэгжсэн байна.
2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиас нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа 26 заалтын хэрэгжилтийг тооцоход 59.6%-тай хэрэгжсэн байна.

Дүгнэлт: Хүнсний тухай хууль болон зарим тогтоолуудтай уялдан журмуудад өөрчлөлт ороогүй, батлагдаагүй нь хэрэгжилт бүрэн хангагдахгүй байх, зохицуулалтын үр дүнг бууруулах үндэслэл болж байна.

1.2. Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянахад оролцогч талуудын бүтэц, чиг үүрэг, ажлын уялдаа холбоо зохистой байна уу?

ХАБ-ын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд төрийн болон ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллахаар тусгасан боловч хэрэгжилтэд хяналт тавих бүтэц, чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг зохистой хуваарилах эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

1.2.1. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хоорондын ажлын уялдаа холбоог нэгдсэн бодлогоор зохицуулсан уу?

Төрийн болон ТББ, мэргэжлийн холбоодын ажлын уялдаа, эрх үүргийг Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3² дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1³ дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5⁴ дахь заалт, хөтөлбөрүүдэд дараах байдлаар тусгажээ. Тухайлбал:

- Хүнсний тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;
- Сургалт, сурталчилгааг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Хөтөлбөрт⁵ салбар зөвлөл ажиллаж, бүрэлдэхүүнд нь ТББ, хувийн хэвшлийн төлөөлөл орж ажиллах;
- Мал эмнэлгийн⁶ үйлчилгээний анхан шатны түвшинд ажиллах малын эмчийг захиалгаар бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг ТББ, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- Явцын болон хөндлөнгийн хяналт-шинжилгээг хүнс, хөдөө, аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, ТББ-ын төлөөлөлтэй хамтран жил бүр хийж гүйцэтгэх.

Эдгээр зохицуулалтын хүрээнд 2018-2020 онд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төрийн болон ТББ-ууд хамтран дараах ажлыг гүйцэтгэжээ.

- ❖ НМХГ нь чиг үүрэгт тусгагдсаны дагуу төрийн болон ТББ-тай хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Тухайлбал:
 - НХХААГ-тай хамтран Хүлэмж зоорины үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт, Нийслэлийн нутаг дэвсгэрт хотын ойролцоох сум суурин газраас нийлүүлэгдэж буй малын түүхий сүүний гарал үүсэл, баталгаажилт, чанар аюулгүй байдалд шинжилгээт хяналт шалгалт, Мал аж ахуйг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд мал бүхий иргэд, фермийн үйл ажиллагаа эрхлэгчдэд сургалт зохион байгуулсан;
 - НХГБХГ-тай хамтран Хүүхэд гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид үнэлэлт дүгнэлт өгөх, ач холбогдлыг нийтэд сурталчилж хүүхдийн эрүүл мэндийг бага наснаас нь анхаарч эрүүл өсөж бойжиход хоол хүнсний зохицуулалт чухал үүрэгтэй болох талаарх мэдлэг мэдээллийг эцэг эхчүүдэд олгож, зөвлөмж гарын авлага, Нийгмийн эрүүл мэндийн өмнө тулгамдаж буй хоол хүнсний талаар сургалт, семинар хамтран зохион байгуулсан;
 - МХХ-той хамтран хүнсний үйлдвэрлэлд нэвтэрч буй шинэ дэвшилтэт техник, технологийн талаарх мэдээлэл солилцох, Нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй баталгаатай эх орны үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүнээр хангах зорилтын хүрээнд үйлдвэрлэл эрхлэгчдийг ХАБ-ыг хангуулах тухай хууль, тогтоомж тэдгээрийг дагалдаж гарсан дүрэм, журам, стандарт, хүнсний бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, зөв сонголтын талаарх мэдээллээр хэрэглэгчдийг хангаж, хамтран ажиллажээ.
- ❖ НХХААГ нь чиг үүргийн хүрээнд төрийн болон ТББ-тай хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал:

² 13.3.Хуульд заасан хүрээ, хязгаарын дотор мэргэжлийн холбоо болон бусад ТББ, иргэн ХАБ-д хөндлөнгийн хяналт тавьж болно.

³ 14.1. ТББ хүнсний аюулгүй байдлыг хангахад дараах чиглэлээр оролцоно

⁴ 5.5.Хяналт шалгалтын бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус мэргэжлийн бусад байгууллага, шинжээч, шинжилгээний байгууллага, иргэнийг татан оролцуулж болно.

⁵ ЗГ-ын 2017 оны 223 дугаар тогтоолын хавсралт “ЖИМС, ЖИМСГЭНЭ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР 7.3 дах заалт

⁶ Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоолын хавсралт “МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

- Органик хүнс үйлдвэрлэгчдийн чуулганыг НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн Монгол дахь суурин төлөөлөгч, Монголын бүтээмжийн байгууллага, Органик монгол ТББ-тай хамтран зохион байгуулсан;
 - Нийслэлийн нутаг дэвсгэрт шингэн сүү худалдаж буй цэгүүдэд шинжилгээ хяналтыг МХХ, Глобал Коммунист ОУБ-тай тус тус хамтран зохион байгуулсан.
- ❖ УБЗАА нь чиг үүргийн хүрээнд төрийн болон ТББ-тай хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал:
- Хүнсний салбарын мэргэжлийн холбоодтой хамтран “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээг зохион байгуулсан;
 - Хоол зүй, шим судлалын Монголын нийгэмлэг ТББ-тай хамтран “Хүүхдийн хоолны жор” технологи ном хэвлэсэн;
 - МҮХАҮТ-тай худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр “Санамж бичиг” байгуулсан.

Дүгнэлт: Нийслэлд хэрэгжих ХАБ-ын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавин ажиллах чиг үүрэг бүхий байгууллагууд нь төрийн болон ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллахаар зохицуулагдажээ.

1.2.2. Хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг зохистой хуваарилсан уу?

ХАБ-ын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг нь НМХГ, УБЗАА-нд, дэмжлэг үзүүлэх, арга хэмжээг зохион байгуулах нь НХХААГ-т тус тус байна.

УБЗАА⁷-ны ХҮХҮХ нь 7 хүний бүтэц, орон тоотой, нийслэлийн нутаг дэвсгэрт хүнс үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, холбогдох хууль, стандартын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах чиг үүрэгтэй.

НМХГ⁸-ын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хэлтэс, Экспорт импорт хорио цээрийн хэлтэс, Эрүүл мэндийн хяналтын 3 хэлтэс нь нийт 127 хүний бүтэц, орон тоотой хүнсний чиглэлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, тээвэрлэлт, хадгалалттай холбогдох хууль, стандарт, дүрэм, зааврыг хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхэлж байгаа байгууллага, иргэд хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих, хүнсний үйлдвэрлэл үйлчилгээний байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хэрэгжүүлж байгаа байдалд дүгнэлт гаргах чиг үүрэгтэй.

НХХААГ⁹ нь 26 хүний бүтэц, орон тоотой нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах талаар төрөөс баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, хүнсний үйлдвэрлэлийн салбарт нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэгтэй.

НМХГ нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу, УБЗАА, НХХААГ нь дүрэмд заасны дагуу хамтарсан болон дангаараа хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Аудитын явцад шалгагдагч байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээтэй танилцахад ХАБ-ын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй төрийн байгууллагууд хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаа боловч НЗДТГ-т нийслэлийн хэмжээнд хэрэгжих ХАБ-ын бодлого төлөвлөлтийг хийх нэгж байхгүй,

⁷ НЗД-ын 2019 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/719 захирамж “Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрэм шинэчлэн батлах тухай”

⁸ ЗГ-ын 2003 оны 37 дугаар тогтоолын хавсралт “Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм”

⁹ НЗД-ын 2016 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/758 захирамж “Дүрэм батлах тухай”

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

УБЗАА-ны ХҮХҮХ нь хяналт тавих чиг үүрэг нь тодорхой бус¹⁰ байгаагаас эрхлэх асуудлын хүрээг тодорхойлох, хуваарилах зохицуулалт хангалтгүй байна.

Мөн дүүргүүдийн хэмжээнд ХАБ-ын үйл ажиллагааг сайжруулахаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- УИХ-аас 2017 онд баталсан “Малын генетик нөөцийн тухай хууль”, ЗГ-ын 2018 оны 267 дугаар тогтоол, НЗД-ын 2018 оны А/1199 дүгээр захирамжаар нийслэлийн зургаан дүүрэгт малын үржил бүртгэлийн асуудал эрхэлсэн “Хөдөө аж ахуйн тасаг” байгуулахаар баталсан. Гэвч шийдвэрийн дагуу ХУД, БНД-т тасаг байгуулаагүй;
- БЗД, НД, СХД, БХД, ХУД, БНД нь хөдөө аж ахуйн тасгийг мэргэжлийн бус хүний нөөцөөр бүрдүүлсэн байна. Энэ нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн асуудлаар арга зүйн зөвлөмж өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зохицуулалт хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Үүнээс харахад нийслэлийн хэмжээнд ХАБ-ыг хангах бодлого, зорилтыг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх зарчмаар үйл ажиллагааг зохицуулах, хянах асуудлын хүрээ буюу төрийн байгууллагын бүтэц чиг үүргийн хуваарилалт оновчгүй, мөн тэдгээрийг бодлого арга зүйгээр удирдаж, хяналт зохицуулалт хэрэгжүүлэх тогтолцоог нийслэлийн удирдлагын түвшинд зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

Дүгнэлт: ХАБ-ын хэрэгжилтэд хяналт тавих бүтэц, чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг зохистой хуваарилах эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна.

1.2.3. Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулсан зөрчлийг илрүүлэх, бүртгэх, зөрчлийн суурь шалтгааныг тодорхойлж арилгах, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, нутгийн захиргаа болон салбар хоорондын хамтын ажиллагааны үр дүнтэй арга хэлбэрийг хэвшүүлсэн үү?

График № 1 НМХГ-ын ажлын схем



Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3¹¹ дахь заалт, ЭМС-ын 2017 оны А/328 тоот тушаалаар батлагдсан “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах журам”, “Хоолны хордлого, хордлогот халдварын голомтод ажиллах заавар”-ын дагуу НМХГ-ын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар хоолны хордлого, хордлогот халдварын голомтод эрүүл ахуй, тархвар судлалын тандалт хийн, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, таслан зогсоох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил

¹⁰ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалт “Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны Засаг даргын хяналт шалгалт, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон мэргэжлийн хяналт, түүнчлэн нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна”


¹¹ 5.3. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг мэргэжлийн хяналтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэ хуулийн 5.2-т заасан удирдамжгүйгээр хийж болно.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулан ажилладаг байна.

Улаанбаатар хотод 2016-2020 оны байдлаар хоолны хордлогот халдварын 24 дэгдэлт бүртгэгдэж, нийт 1037 хүн өвчилсөн. Тухайн онуудад гарсан дэгдэлтийн 33.3% нь нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт, 25.0% нь гэр ахуйн нөхцөлд, 12.5% нь арга хэмжээний үеэр, үлдсэн 29.2% нь байгууллагын ажилчдын цайны газарт, хүнсний үйлдвэр, ерөнхий боловсролын сургууль, ТҮЦ, тусгаарлан ажиглах зочид буудалд гарчээ.

График №2 Хоол хүнснээс шалтгаалсан хордлого



Тухайлбал: ХУД-ын “Зайсан KFC” салбарт 2019 онд гарсан хоолны хордлогот халдварын дэгдэлтэд 308 хохирогч бүртгэгдсэн, НМХГ-ын улсын байцаагчийн дүгнэлтээр “Хүнсний бүтээгдэхүүний нян судлалын аюулгүйн үзүүлэлт, үнэлгээ”, “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”-ээр чанарын болон аюулгүй байдлын шаардлагыг хангаагүй. Шалгалтын явцад ундны усны бохирдлын шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор усны давтан шинжилгээ хийж, УСУГ-ын мэргэжлийн багаар шугам хоолойг халдваргүйжүүлэн цэвэрлэсэн байна.

НМХГ нь иргэдээс ирсэн гомдол, мэдээллийн дагуу хордлогот халдварын дэгдэлтийг тодорхойлох зорилгоор ХӨСҮТ-өөр шаардлагатай шинжилгээг хийлгэж, холбогдох бусад төрийн байгууллагуудтай хамтран зөрчлийг арилгуулж, албан даалгавар хүргүүлэх, үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоох, торгууль ногдуулах, хохирол барагдуулах арга хэмжээг авч ажиллажээ.

Дүгнэлт: Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд хохирол учруулсан зөрчлийг илрүүлэх, арилгах, хяналт, хариуцлагын тогтолцоо нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан хийгдэж байна.

1.2.4. Хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хордлого, халдварын тохиолдол, онцгой нөхцөл байдал, хямрал үүсэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, салбар дундын зохицуулалт байна уу?

НМХГ, НХХААГ, УБЗАА-н ХҮХҮХ-ээс жил бүр нийтийг хамарсан томоохон баяр наадмын өмнө ард иргэдийн ХАБ-ыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлээр НЗД, МХЕГ, УБ хотын Ерөнхий менежерийн гаргасан удирдамжийн дагуу жилд 4 удаа хамтарсан багийн шалгалт хийдэг.

НМХГ нь Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 8 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай

зохион байгуулах журам"-ыг баримтлан ажиллаж байна. Уг журмын зорилгын 1.2-д заасны дагуу нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын төрөлд хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн талаар, 4.2-т /Хүснэгт 2/ хамтран ажиллах байгууллагын талаар тусгажээ. ХАБ алдагдах, хүний эрүүл мэндэд хохирол учруулах, хоолны хордлогын эмнэл зүйн ижил шинж тэмдэг илрэхэд ЭМС-ын 2017 оны А/328 тоот "Журам заавар, шинэчлэн батлах тухай" тушаалыг удирдлага болгон ажилладаг.

Нийслэлийн хэмжээнд ХАБ алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах үеийн төлөвлөгөөг жил бүр УБЗАА-ны ХҮХҮХ баталдаг. Төлөвлөгөөнд хөл хорио тогтоосон үеийн хүнсний нөөц, хүнсний хангамж, нийлүүлэлтийн бэлэн байдлыг хангаж ажиллахаар тусгаж, онцгой нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлэх "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон бусад албадын төлөвлөгөөтэй уялдуулан хамтран ажиллахаар тусгажээ.

Дүгнэлт: Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал алдагдах, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн үед НМХГ, ХӨСҮТ, НМЭГ, НОБГ, НЦУГ зэрэг байгууллагууд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар зохицуулагджээ.

1.3. Монгол Улс хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан чанарын стандарт, олон улсын жишигт нийцсэн эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй, баталгаатай хангагдсан уу?

Нийслэлийн хэмжээнд хэрэглэгчдэд хүрэх үе шат буюу мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтад тавих хяналтын үр нөлөө багатай, хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, ААН-н нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоо муу, бүртгэл зөрүүтэйгээс эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хүртээмжтэй, баталгаатай хангагдах нөхцөл бүрдээгүй байна. Мөн хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хоол хүнсээ хэрэглэх, хадгалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ жил бүр өссөн үр дүнтэй байгаа хэдий ч хэрэглэгчийн идэвх оролцоотойгоор хоол хүнсээ сонгох хандлагыг өөрчлөх, зөв дадал төлөвшүүлэх арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Нийслэлийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангаагүй чанарын стандарт, олон улсын жишигт нийцээгүй, эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр жигд, тогтвортой, хүртээмжтэй, баталгаатай хангагдаагүй байна.

1.3.1. Монгол Улсын гол нэрийн хүнсний нөөцийн тооцооллын үндэслэл болон аймаг, нийслэлд болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийн асуудлын шийдвэрлэлт оновчтой, улсын нөөцийн сэлгэлт, хадгалалт, хамгаалалт зохих түвшинд баталгаатай байна уу?

Монгол Улсын гол нэрийн хүнсний нөөцийн тооцооллыг хүнсний хангамж, хүнсний илчлэг, шим тэжээл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлтүүдээр ҮСХ-ны даргын 2015 оны А/12 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад заасан "Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал", ЭМС-ын 2017 оны А/74¹² дүгээр тушаалаар Монгол хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ зэрэг үзүүлэлтийг үндэслэл болгодог байна.

¹² Жич: "Хоногийн хоол хүсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ"-гээр жишсэн нэг хүний нэг хоногийн хүнснээс авах илчлэг, шим тэжээлийг 2400 ккал байхаар тооцсон байдаг ба гамшгийн үед уг хэмжээний 87 хувь буюу 2088 ккал байх нь тохиромжтой гэж үздэг.

Нийслэлд болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийг байгалийн гамшиг, газар хөдлөлт, аюулт үзэгдэл болон техникийн холбогдолтой ослын үед голомтод ажиллаж байгаа шуурхай бүлэг, аврагчид, нэрвэгдэгсдийг хоол хүнсээр хангах, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор зохион байгуулж, гүйцэтгэх үүрэг бүхий "Хүнсээр хангах алба" нь УБЗАА-ны ХҮХҮХ-т хамааран ажилладаг.

Албаны чиг үүргийн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиудыг удирдлага болгон 9 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх 3 талт "Болзошгүй гамшгийн үед бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ"-г хүнсний бүтээгдэхүүн боловсруулж, үйлдвэрлэдэг 77 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

НЗД нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2¹³ дахь заалтаар "Хүнсээр хангах алба" байгуулсан боловч мөн хуулийн 32.1.1¹⁴ дэх заалтыг хэрэгжүүлээгүйгээс арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх чиг үүрэг орхигдож, нийслэлийн хүнсний нөөцийн асуудалд орон нутгаас төсөв гардаггүй, худалдан авалт хийгдэж байгаагүй тул нэр төдий байдлаар нөөцийн сэлгэлт, хадгалалт, хамгаалалтыг хувийн хэвшлийн нөөцөд тулгуурлан гэрээний үндсэн дээр шийдсээр ирсэн байна.

Үүнээс харахад нийслэлд болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийн сэлгэлт, хадгалалт, хамгаалалтын асуудалд нэр төдий байдлаар хандаж, оновчгүй шийдвэрлэсээр иржээ.

Дүгнэлт: Нийслэлд болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийн асуудлын шийдвэрлэлт оновчгүй, нөөцийн сэлгэлт, хадгалалт, хамгаалалт баталгаагүй байна.

1.3.2. Хүнсний шим тэжээл, чанар, аюулгүй байдлыг шинжилж байгаа лабораторийн тоо, тоног төхөөрөмж, түүний хүчин чадал өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж, үйл ажиллагаа нь зохих түвшинд тогтмол ажиллаж байна уу?

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Хяналтын байгууллагын дэргэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн талаарх лабораторийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн санг удирдах", энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний лавлагаа лаборатори ажиллана" гэж заасан байдаг бөгөөд тус чиг үүргийг Мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэдэг.

Мэргэжлийн хяналтын системд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, нийслэлд НМХГ-ын Төв лаборатори, орон нутагт 21 аймагт Мэргэжлийн хяналтын лабораториуд ажиллаж байна.

НМХГ-ын Төв лаборатори нь 1997 оноос хойш 8 удаа итгэмжлэлд хамрагдаж, 2019 онд итгэмжлэлийн эрхээ 4 жилийн хугацаатай сунгуулсан. Хими, хор судлалын лаборатори, микробиологийн, ургамал хорио цээрийн лаборатори гэсэн 2 үндсэн том лаборатори, 16 нэгж лаборатори ажилладаг.

Лабораторийн хүчин чадлыг бэхжүүлэх ажлууд 2000 оноос эхлэн лабораторийн шинжилгээнд орчин үеийн олон улсын дэвшилтэт технологиуд нэвтрүүлж, орчин үеийн өндөр мэдрэг багажууд болох хийн хроматограф, атом шингээлтийн спектрометр аппаратуудаар тоногложээ.


¹³ 32.1.2. нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох;

¹⁴ 32.1.1 "нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх"

Тус лабораторид жилдээ 65,000 орчим ААН-ийн үйлдвэрлэж буй дотоодын бүтээгдэхүүн болон түүхий эдэд хүрээлэн буй орчны хөрс, бохир ус, бүх төрлийн усанд хими, нян судлалын шинжилгээ, микотоксин, хүнд металл зэрэг хорт бодисуудын үлдэгдэл тодорхойлох, ажлын байрны агаарт хорт бодисуудын ууршилт тодорхойлох зэргээр 625 стандарт, 304 аюулгүйн үзүүлэлтээр хүнсний бүтээгдэхүүний шинжилгээ хийж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 21483 сорьцод шинжилгээ хийснээс 1181 сорьц буюу 5.5% нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй байна. Үүнийг 3 жилээр харуулбал:

График №3 НМХГ-ын Төв лабораторид шинжлэгдсэн нийт сорьц 2018-2020 он



Эх сурвалж: НМХГ-ын Төв лабораторийн тайлангаас

Төв лабораторид нийт 238 төрлийн 299 ширхэг 1,547.6 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглаж байна. Үүний 10% нь 2000 оноос өмнө, 82.6% нь 2000-2015 онд, 7.4% нь 2015 оноос хойш авсан тоног төхөөрөмж байна. Эндээс харахад дийлэнх буюу 80% нь ашиглалтын шаардлага бүрэн хангахгүй болж орчин үеийн хүнсний болон бэлэн бүтээгдэхүүний түүхий эд олширч тэдгээрийн физик, химийн шинж чанар өөрчлөгдсөн, техник технологийн дэвшил, өөрчлөлтөөс шалтгаалан үйлдвэрлэх, савлах, хадгалах, тээвэрлэх шатанд шинэчлэлүүд хийгдэж байгаатай холбоотойгоор өнөөгийн хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах шаардлагатай байна.

2012 оноос хойш лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлууд хийгдээгүйгээс шалтгаалан хэмжилтийн тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтэл их гарч, үнэн бодит үр дүнгээр иргэн, ААН байгууллагыг хангахад эрсдэл бий болсон байна.

Хийгдэж буй хүчин чадлыг харьцуулбал стандарт үзүүлэлтээс хими, хор судлалын шинжилгээ 54.0%, нян судлалын шинжилгээ 53.3%, ургамлын үр, хорио цээрийн шинжилгээ 55.0 орчим хувьтай хийгдэж байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

График №4 Лабораторийн хүчин чадал



Эх сурвалж: НМХГ-ын Төв лабораторийн тайлангаас

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

НМХГ-ын Төв лаборатори нь жил бүрийн төсвийн төсөөлөлд лабораторийн хүчин чадлыг бэхжүүлэхэд нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмж авах, эвдрэл гэмтлийг засуулах засварын зардал болох 190.0-350.0 сая төгрөгийн саналыг явуулж байсан боловч одоог хүртэл багаж тоног төхөөрөмжийн төсвийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.



Зураг №1 НМХГ-ын Төв лабораторийн тоног төхөөрөмж

НМХГ-ын Төв лабораторийн 2 давхар барилга нь 2010 оны 07 сарын 20-ны өдрийн 06/10/123 дугаар бүхий “Барилгын ашиглалтыг зогсоох тухай” улсын байцаагчийн акт гарсан хэдий ч одоогоор ашиглаж үйл ажиллагаагаа явуулсаар байна.



Зураг №2 НМХГ-ын Төв лабораторийн барилга

Улсын байцаагчийн дүгнэлтээр: Барилгын ашиглалтын хугацаа дууссан, үндсэн хийц бүтээц нь “Газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм”-ийн шаардлагад нийцэхгүй, газар хөдлөлт, байгалийн болзошгүй гамшгийн үед хөндлөн хүчний үйлчлэлийг тэсвэрлэх чадваргүй, суурь хөрс хэв гажилтад орж үндсэн даацын хийц бүтээцэд хагарал үүсэж улсын байцаагчийн 2007 оны 07 сарын 02-ны өдрийн 05-11/1536 тоот албан шаардлагад дурдсанаас хагарлын хэмжээ нэмэгдэж байгаа зэргээс үзэхэд орчин тойронд болон олон нийтэд ноцтой хохирол учруулахаас гадна нурах аюултай болсон нь “Барилгын тухай” хуулийн 9.1.1 /хүн ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан/ дүгээр зүйлийн шаардлагыг ноцтой зөрчсөн гэсэн дүгнэлт гарчээ. Тус дүгнэлтээс харвал Төв лабораторид дараах эрсдэлүүд үүсэж байна. Тухайлбал:

- НМХГ-ын Төв лабораторид 12 нэр төрлийн 28 нянгийн өсгөвөртэй. Бичил биетний 2-р зэргийн лабораторид хадгалагддаг эмгэг төрөгч бактерийн стандарт цэвэр өсгөвөр алдагдсан үед агаараар дамжин хүрээлэн буй орчин болон хүн, амьтанд хурц болон цочмог хоолны хордлого үүсгэх аюултай;

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

- Ариутгал, халдваргүйтгэл хийдэг уурын даралтат аппарат болох автоклав нь цахилгааны болон бусад шалтгаанаар тэсэрч дэлбэрэх аюултай;
- Төв лаборатори нь 109 нэр төрлийн химийн хуурай бодис болон органик уусгагч, 4 төрлийн даралтат хий хэрэглэдэг. Хэрэв дээрх бодисууд нь агаарт дэгдсэн тохиолдолд эргэн тойрны орчимд байгаа хүнд хорт хавдар үүсгэх, нөхөн үржихүйн болон үр удамд нөлөөлөх хор хөнөөлтэй;
- Даралтат хийнүүд нь дулааны нөлөөгөөр тэсрэх дэлбэрэх аюултай.

НМХГ нь олон улсын стандартад нийцсэн лабораторийн барилга бариулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны төхөөрөмжүүд, лабораторийн тавилгаар тоноглуулах зорилгоор НИТХ-ын ажлын албанд 2021.09.23-ны 02-01/2856 тоот албан бичгээр тус барилгыг дахин барих 12,353.1 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлт өгсөн байна.

Дүгнэлт: НМХГ-ын Төв лабораторийн барилга, техник, тоног төхөөрөмж нь стандартын шаардлагад нийцэхгүй, хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл өндөр байна.

1.3.3. Монгол Улсад хүнсний дотоодын үйлдвэрлэл болон импортын зохистой харьцаа хангагдаж, хүнсний хангамжийн бодлогыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хүнсний хангамжийг бүрдүүлэх чиглэлээр дараах зорилтууд тусгагджээ. Тухайлбал:

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх

- 1.3.1 Нийслэлийн хүн амын хүнсний эрүүл, аюулгүй бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулж, бодлогын хэрэгжилтийг хангана.
- 1.3.3 Мал аж ахуйг эрчимжсэн цогц байдлаар хөгжүүлэн, сүү, махны фермерийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх замаар нийслэлийн хүн амын сүү, махны хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангана.
- 1.3.4 Малын захыг мах боловсруулах үйлдвэрийн хамт хотын зүүн, баруун бүсэд байгуулж, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлагад нийцсэн, баталгаат бүтээгдэхүүн нийлүүлнэ.

Энэ чиглэлээр дараах ажлууд хийгджээ. Тухайлбал:

- “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд шингэн сүү 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30,726.8 мянган литр сүү боловсруулж үйлдвэрлэсэн, нийт 1526.9 га талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл тариалахаар төлөвлөж хураасан;
- “Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд СХД-ийн Бэлчээрийн менежментийн төслийн газарт 90 үхрийн зогсоол бүхий аж ахуйн байгууламж байгуулсан;
- Хотын зүүн, баруун буюу БЗД, СХД -ийн бүсэд малын захыг мах боловсруулах үйлдвэрийн хамт байгуулах ажил 70-80%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.
- Нийслэлийн иргэдийн хэрэгцээнд зориулан 2020 онд 46 ААН-ээс 27.5 мянган тонн мах бэлтгүүлэн авч худалдан борлуулсан.

Дүгнэлт: Нийслэлийн хэмжээнд хүнсний хангамжийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ тайлант жилдээ үр нөлөөтэй хэрэгжжээ.

1.3.4. Хүнсний сүлжээ тухайлбал, бүтээгдэхүүнийг импортлох болон дотоодод үйлдвэрлэж эхлэхээс хэрэглэгчдэд хүрэх хүртэлх хугацааны бүх үе шатанд (мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалт) хэрэгжсэн чанарын удирдлага, хяналт баталгаажуулалт үр нөлөөтэй, олон улсын жишигт нийцсэн байна уу?

НСГ-ын мэдээллээр 2020 оны байдлаар нийслэлд 1.6 сая хүн ам, 414.3 мянган өрх байгааг тусгасан нь Монгол Улсын нийт хүн амын тал хувь нь нийслэлд амьдарч байгааг харуулж байна.

Аудитаар хүн амын хүнсний хэрэглээг хангах буюу бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалт зэрэг хэрэглэгчдэд хүргэх бүх үе шатны үйл ажиллагааны хяналтыг Хүчит шонхор, Хар хорин, Амгалан, Барс, Баянзүрх зэрэг томоохон зах худалдааны төвүүдээс түүвэрлэн үзэхэд дараах нийтлэг зөрчлүүд байна. Тухайлбал:

- Махыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ гэж заасан боловч хэрэгждэггүй. Тээврийн хэрэгслийн ариун цэвэр хангалтгүй;
- Махыг зориулалтын хөргүүрт байрлуулж борлуулаагүй;
- Загас, далайн гаралтай бүтээгдэхүүнийг бусад махтай хамт нэг хөргүүрт байрлуулж борлуулсан;
- Зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэж, худалдаж байгаа нөхцөл байдал арилаагүй;
- Махны худалдаа эрхлэгч, ААН QR код хэрэглэж хэвшээгүй;
- Хөдөө орон нутгаас ирж буй махны тоо хэмжээ мал эмнэлгийн бүртгэлийн системээс зөрдөг;
- Хүнсэнд хориглосон сав баглаа боодол, гялгар уутыг нийтлэг хэрэглэсэн;
- Хөлдөөгчийн температур хэмжсэн, бүртгэсэн, хянасан бүртгэл байхгүй;
- МХЕГ-ын даргын А/179 дүгээр тушаалын “Хүнсний худалдааны газарт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм” -ийн цэвэрлэгээ угаалга, халдваргүйтгэлд тавих эрүүл ахуйн шаардлага 8.1-8.4 дэх заалтуудыг хэрэгжүүлж хэвшээгүй;
- Махны худалдаа эрхлэгч нар зориулалтын хувцас өмсөөгүй;
- Өдөр тутамдаа эрүүл ахуйч нь мэдрэхүйн шинжилгээгээр хяналт хийдэг. Тогтмол хугацаанд түүврийн аргаар махны дээжийг өөрийн лабораторид шинжилдэг. Шаардлагатай тохиолдолд НМХГ-ын төв лаборатори болон НМЭГ-ын лабораторид шинжлүүлж малын маханд тарилга хийснээс хойш хугацаа баримталж хүнсэнд хэрэглэсэн эсэхийг шалгуулдаг;
- Хэрчсэн гурил, кимчи, мантуу, өндөг зэрэг бүтээгдэхүүний хадгалах горимыг зөрчиж борлуулсан;
- Зориулалтын агуулах байхгүй, худалдаа эрхлэгчдэд стандартын шаардлага хангаагүй гадаа контейнерыг түрээслүүлдэг;
- “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам”¹⁵- 3.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй /Дотоод хяналтын нэгжгүй/;

¹⁵ 3.1. Тухайн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналтын нэгжийг эсхүл ажилтныг томилно.



Зураг №3 Зах, худалдааны төвөөс илэрсэн зөрчлийн байдал

Аудитаар хүн амын хүнсний хэрэглээг хангах арга хэмжээний зарим хэсгийг түүвэрлэн хамруулахад үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах, хүргэх бүх үе шатанд багагүй зөрчил, дутагдал, зохицуулалтын доголдол харагдаж байгаа нь ХАБ-ын асуудал зөрчигдөх байдал тасрахгүй байгааг харуулж байна.

Дүгнэлт: Хэрэглэгчдэд хүрэх үе шат буюу мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтад тавих хяналт алдагдсан, хяналтын үр нөлөө багатай, жишиг стандартад нийцээгүй.

1.3.5 Хүнсний сүлжээний бүх үе шатны нэгдсэн бүртгэл, хяналт, мэдээллийн тогтолцоо үр дүнтэй байна уу?

Нийслэлийн хэмжээнд ХАБ-г хангуулж хянах чиг үүрэгтэй НМХГ, УБЗАА-ны ХҮХҮХ нь хүнсний үйл ажиллагаа эрхлэгч иргэн, ААН-н судалгаа, мэдээллийг бүртгэж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөн НМТГ нь бүртгэл мэдээллийн сан үүсгэн ажилладаг бөгөөд эдгээр байгууллагын тоон мэдээллийг харьцуулан үзэхэд зөрүүтэй байна.

Хүснэгт №1 Хүнсний чиглэлээр нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААН-ийн тоон мэдээлэл

№	Хүнсний чиглэл	Төрийн захиргааны байгууллагын нэр	Хүнсний чиглэлээр нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААН-ийн тоо мэдээлэл									
			БГД	БЗД	ХУД	ЧД	СБД	СХД	БНД	БХД	НД	Нийт
1	Хүнсний худалдаа	УБЗАА, ХҮХҮХ	556	990	617	723	463	1,115	97	19	187	4,821
		НМХГ	705	1,969	831	731	664	1,330	113	13	146	6,502
		НМТГ	461	1,909	695	574	621	899	79	11	78	5,327
2	Хүнсний үйлдвэрлэл	УБЗАА, ХҮХҮХ	100	66	72	50	52	151	12	-	13	504
		НМХГ	119	201	81	54	49	219	36	-	20	779
		НМТГ	22	12	202	74	82	500	30	-	6	928
3	Хоол үйлдвэрлэл	УБЗАА, ХҮХҮХ	680	432	313	476	689	432	63	4	32	3,121
		НМХГ	903	1,174	388	370	661	523	72	11	98	4,200
		НМТГ	1,104	1,510	628	638	1,456	616	78	2	34	6,066

Хүснэгтээс харахад 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийслэлд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААН-ийн тоо мэдээлэл хяналтын чиг үүрэг бүхий НМХГ, УБЗАА-н ХҮХҮХ-т хүнсний худалдаанд 1681 иргэн, ААН-ээр, хүнсний үйлдвэрлэлд 275 иргэн, ААН-ээр, хоол үйлдвэрлэлд 1079 иргэн, ААН-ээр зөрүүтэй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

Харин төрийн бүх шатны байгууллагуудыг нэгдсэн мэдээллийн сангаар хангах чиг үүргийн хүрээнд НМТГ нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа эрхлэгч иргэн, ААН-ийн нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлж байгаа нь төрийн байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж, төрөөс хүнсний талаар баримтлах бодлого, түүнд тавигдах хяналт, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ.

Дүгнэлт: Нийслэлийн хэмжээнд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, ААН-ийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоо муу, бүртгэл зөрүүтэйгээс хяналтын үр дүнг бууруулж байна.

1.3.6. Шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3¹⁶, 16 дугаар зүйлийн 16.4¹⁷, Органик хүнсний тухай хууль, "Алсын хараа 2050"-ын 2.5.5¹⁸, "ЗГ-ын 2016 -2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-ийн 2.20¹⁹, "НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-ийн 1.3.2 дахь заалтад органик үйлдвэрийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх талаар тусгажээ.

Нийслэлийн хэмжээнд 2021 оны байдлаар 6 иргэн, ААН нь 52 нэр төрлийн органик хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаас 10 бүтээгдэхүүнийг баталгаажуулж, 42 бүтээгдэхүүн шилжилтийн үе шатанд байна. Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх онтой харьцуулахад органик хүнс үйлдвэрлэгч 1 ААН-ээр нэмэгдэж, бүтээгдэхүүн нэр төрөл 35 буюу 3 дахин өссөн байна. Дүүргүүдээр харуулбал:

Хүснэгт №2 Органик хүнсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл

Огноо	Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн нийт тоо	Үйлдвэрлэж буй органик хүнсний тоо	Үүнээс	
			Баталгаажсан	Шилжилтийн үе
2020 он	5	17	12	5
2021 он	6	52	10	42

Органик хүнсний тухай хууль батлагдсантай холбогдуулан ХХААЯ-аас “Органик хүнс” хөдөө аж ахуйн үндэсний I, II, III, IV чуулган болон “Оролцооны баталгаажуулалт”, “Органик хүнсний баталгаажуулалт”, “Органик бордоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1,500 гаруй төлөөллийг хамруулсан, Органик хүнсний бүртгэл, мэдээлэл бүхий www.organic.gov.mn сайт ашиглалтад оруулсан байна.


¹⁶ 8.1.3.хүүхдийн хоол тэжээл болон органик хүнсний үйлдвэрлэл;

¹⁷ 16.4.Органик хүнсний холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

¹⁸ 5.Инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж аюулгүй, тэжээллэг хэрэгцээт хүнсээр хангадаг болно.

¹⁹ 2.20.Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний эрх зүйн орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалт, татварын бодлогыг хэрэгжүүлнэ.

 Органик хүнснийг баталгаажуулсан тэмдэг, тэмдэг тэмдэглэгээний тайлбар



Зураг №4 Органик хүнснийг баталгаажуулсан тэмдэг, тэмдэглэгээний тайлбар

Органик хүнс үйлдвэрлэх эрх зүйн орчин бүрдэж, хүнс үйлдвэрлэгч болон бүтээгдэхүүний хэмжээ өсөлттэй байгаа нь бодлогын хэрэгжилт үр дүнтэй байгааг харуулж байгаа боловч иргэдэд органик хүнсний бүтээгдэхүүний тэмдэг, тэмдэглэгээний талаар мэдээлэл өгөх, танин мэдэхүйн сургалт, сурталчилгааг илүү хүртээмжтэй хүргэх шаардлагатай байна.

Дүгнэлт: Органик болон шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого хэрэгжиж байна.

1.3.7. Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэхэд тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй байна уу?

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйл, "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.4.2.6, УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын 4.1.10, ЗГ-ын 2015 оны 496 дугаар тогтоолоор баталсан "Хүнсний зориулалтын бус хуванцар савны талаар авах зарим арга хэмжээний тухай", "Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөр, 2018 оны 189 дүгээр тогтоолоор баталсан "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай", Стандарт, хэмжил зүйн газрын 2016 онд баталсан MNS 6648:2016 "Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага"-д хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэх сав баглаа боодлын талаар тусгажээ.

Аудитаар холбогдох байгууллагуудын мэдээ тайлан, салбарын нөхцөл байдлаас харахад мэргэжлийн байгууллагын хяналтаар дараах зөрчил илэрч байна.

НМХГ:

- 2018 онд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгололтын байдалд тандалт судалгаа хийжээ. Судалгаагаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ААН-ийн удирдлага, иргэдийн хүнсний бүтээгдэхүүний шошгын талаарх болон хууль эрх зүй, шинээр болон шинэчлэн батлагдаж байгаа стандарт дүрэм журмын мэдлэг мэдээлэл хангалтгүй, стандартгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаас хадгалах нөхцөл, хугацаа, тэжээллэг чанар зэрэг үзүүлэлтүүдийг хуулбарлаж, тухайн бүтээгдэхүүний стандартад заасан үзүүлэлтүүдээс зөрүүтэй бичих, иргэдийг буруу мэдээллээр хангах сурталчилгаа хэт туйлшруулж хийх зөрчил, дутагдлыг илрүүлжээ;
- 2019 онд эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт, хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагчид болон Нэгдсэн төв лабораторийн шинжээчид худалдаа, үйлчилгээнд ашиглаж, хэрэглэж буй 300 гаруй төрлийн нийлэг уутыг 100 орчим иргэн, ААН-с түүвэрлэн авч хэмжилтийг хийсэн. Хэмжилтэд худалдааны газарт хэрэглэгдэж буй бүх төрлийн уутнууд /тасалдаг болон жижиглэн савлагаанд хэрэглэгддэг уут, жижиг, дунд, том хэмжээтэй торнууд гэх мэт/, бүх төрлийн гурилан бүтээгдэхүүний уутнууд /талх, нарийн боов, гоймон, хэрчсэн гурил гэх мэт/, мах, махан бүтээгдэхүүний савлагааны уутнууд /бууз, баншны уут, хиа, зайдасны бүрхэвч хальс, тахианы мах, элэгний нухашны уут гэх мэт/, бусад төрлийн буюу чихэр, печень, самар, жүүс, цай, цэвэр ус, соус гэх мэт бүтээгдэхүүний уутнууд хамрагдсан. Нийт хэмжилт хийлгэсэн уутны 64.5% нь шаардлага хангасан, 35.5% нь хангаагүй дүнтэй судалгаа гаргасан;
- 2020 онд “Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд хэрэглэж буй хуванцар сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдал”-д урьдчилан сэргийлэх шалгалт хийжээ. Шалгалтад хүнсний сүлжээний бүх шатны 1191 иргэн, ААН хамрагдаж, 0.035 мм-с доош зузаантай нийлэг хальсан уутыг актаар хураан авч устгуулахаар Нийслэлийн зөвлөлд шилжүүлсэн, худалдаалалтад хориглосон хуванцар савыг татан авах, бусад мэдээлэл, зөвлөмж өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

НХХААГ:

- "Сав, баглаа боодол" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар 69.0%-тай дүгнэжээ.

Зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошготой холбоотой хууль эрх зүйн зохицуулалт байгаа ч мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар зөрчил дутагдал илэрч байгаа нь иргэд, ААН-н дунд зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн хэмжилтийн багаж нийслэл дүүрэг дэх МХХ-ийн улсын байцаагч нарт хүрэлцэхгүй байгаа нь стандарт хангуулах боломжийг хязгаарлаж, үр дүнг бууруулж байна.

Аудитаар хүн амын хүнсний хэрэглээг хангах арга хэмжээний зарим хэсгийг түүвэрлэн хамруулахад сав, баглаа боодол, хаяг шошгын зөрчил багагүй илэрсэн.

Дүгнэлт: Зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэхэд тавих хяналтын тогтолцоо үр нөлөө муутай байна.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

1.3.8. Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна уу?

НХХААГ нь 2018-2020 онуудад төрийн болон ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран нийт 60164 иргэн, ААН-ийг хамруулан “Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах” талаар сургалтыг 69 удаа зохион байгуулсан байна.

Хүснэгт № 3 НХХААГ-аас хүнсний чиглэлээр зохион байгуулсан сургалт

№	Нэгжийн нэр	Сургалтын тоо			Оролцогч			Нийт	
		2018 он	2019 он	2020 он	2018 он	2019 он	2020 он	Сургалтын тоо	Оролцогч
1	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс	21	13	1	1,040	1,360	1,110	35	3,510
2	Газар тариалангийн хэлтэс	2	13	2	80	946	38,485	17	39,511
3	Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс	7	9	1	223	720	16,200	17	17,143
4	Мал үржлийн алба								
Нийт		30	35	4	1,343	3,026	55,795	69	60,164

Хүснэгтээс харахад 2020 онд зохион байгуулсан сургалтын тоо өмнөх оноос 31-р бага буюу 88.5 %-р буурч харин сургалтад оролцогчдын тоо 52,769 мянга буюу 18.4 дахин өсжээ. Шалтгаан нөхцөлийг тодруулахад улсын хэмжээнд цар тахал дэгдэж онцгой нөхцөл байдал үүссэн тул танхимын сургалтын тоо буурч харин сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулснаар оролцогчдын тоо өссөн.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлд мөрдөх стандарт, хүнсний эрүүл ахуйн зохистой дадал, хадгалалт, тээвэрлэлт, хаяг шошгын стандарт, дэвшилтэд технологи нэвтрүүлэх болон тогооч мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх сэдвийн хүрээнд 2018-2021 онд УБЗАА 195 удаа 21,407 иргэн, ААН, НМХГ-с 33 удаа 1,741 иргэн, ААН, эрх бүхий албан тушаалтныг хамруулан сургалтыг зохион байгуулжээ.

Дүгнэлт: Хоол, хүнс хэрэглэх, хадгалах чиглэлээр хэрэгжүүлсэн сургалт, мэдээллийн арга хэмжээ жил бүр өссөн дүнтэй байна.

БҮЛЭГ 2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Хүнсний тухай хуулийн 3.1.2 дахь заалтад “Хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байх” гэж заажээ.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нийслэлийн ЭЗНХҮЧ-д 2018 онд 815,935.4 сая төгрөг, 2019 онд 1,120,752.9 сая төгрөг, 2020 онд 1,191,514.7 сая төгрөг, 2021 онд 2,193,243.8 сая төгрөг байхаар төлөвлөн тусгажээ.

Үүнээс хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөтөлбөрт суурилан ТАХ-г хэрэгжүүлэхэд 2018 онд 2,126.4 сая төгрөг буюу 0.3%, 2019 онд 5,169.7 сая төгрөг буюу 0.5%, 2020 онд 56,015.0 сая төгрөг буюу 4.7%, 2021 онд 5,613.8 сая төгрөг буюу 0.3%-г тус тус эзэлж байна.

2.1. Төсвийг үр ашигтай төлөвлөсөн үү?

Төсвийг төлөвлөхдөө салбарын онцлогийг харгалзаагүй, хэрэгцээ үр ашгаар эрэмбэлээгүй байна.

2.1.1. Хөтөлбөрт суурилсан төсвийг төлөвлөсөн үү?

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нийслэлийн ЭЗНХҮЧ-д 2018 онд 2,126.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ, 2019 онд 5,169.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ, 2020 онд 56,015.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ, 2021 онд 5,613.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-г тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт №4 2018-2021 оны ЭЗНХҮЧ-д тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх ТАХ-ны тоо, санхүүжигдэх дүн

№	Он	ТАХ тоо	Санхүүжигдэх дүн /сая.төг/
1.	2018	18	2,126.4
2.	2019	19	5,169.7
3.	2020	13	56,015.0
4.	2021	16	5,613.8
Нийт		66	68,924.9

Хүснэгтээс харахад нийслэлд хэрэгжүүлэхээр сүүлийн 4 жилийн байдлаар 68,924.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй /давхардсан тоогоор/ 66 ТАХ-г хөтөлбөрт суурилан хүрэх зорилт, хугацаа, шаардлагатай хөрөнгө, эх үүсвэр, хүрэх түвшин зэргээр төлөвлөсөн боловч НИТХ-с тухайн онуудын төсөвт санхүүжилтийг батлаагүй байна.

Дүгнэлт: Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд суурилан арга хэмжээ, төсвийг тусгасан боловч санхүүжилтийг батлаагүй байна.

2.1.2 Зорилт, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө хэрэгцээ, шаардлага, үр ашгаар эрэмбэлсэн үү?

Нийслэлийн ЭЗНХҮЧ-д 2018-2021 онуудад хэрэгжүүлэхээр тусгагдсан ТАХ-с 2018 онд 2,126.4 сая төгрөг буюу 0.3%, 2019 онд 5,169.7 сая төгрөг буюу 0.5%, 2020

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

онд 56,015.0 сая төгрөг буюу 4.7%, 2021 онд 5,613.8 сая төгрөг буюу 0.3% нь хүнс, хөдөө аж ахуйн салбарт чиглэн төлөвлөжээ.

Эдгээр онуудад нийт төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт 0.3-4.7%-ийг буюу маш бага төсвийг зарцуулахаар төлөвлөжээ. Улс эх орны хөгжил нь зам, барилга байгууламж, тохижилт, шинэ дэвшилтэт технологиос хамаарах хэдий ч улс үндэстний хүн амын бодлого, урт удаан оршин тогтнох гол үндэс болсон эрүүл, аюулгүй, чанартай хүнсээр хангагдах, түүхий эдээс эхлэн бүх шатны зөв мэдлэг боловсролтой байх, хоол тэжээлтэй холбоотой аливаа өвчнөөр өвчлөх эрсдэлийг бууруулах, танин мэдэхүйн боловсролыг иргэдэд олон давтамжтай хүргэх, хамгаалах үндэсний аюулгүй байдлын хэмжээний чухал салбарын зорилт, арга хэмжээ нийслэлийн түвшинд бүрэн хэрэгжихгүй, орхигдож байна.

Хүснэгт №5 2018-2021 онуудад ЭЗНХҮЧ-д тусгагдсан дүн, эхлэх хувь

№		2018 он		2019 он		2020 он		2021 он	
		Мөнгөн дүн	Эзлэх хувь	Мөнгөн дүн	Эзлэх хувь	Мөнгөн дүн	Эзлэх хувь	Мөнгөн дүн	Эзлэх хувь
Эдийн засгийн өсөлт өрх бүрт	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	2,126.4	0.3%	5,169.7	0.5%	56,015.0	4.7%	5,613.8	0.3%
	Бусад	6,277.7	0.8%	24,065.5	2.1%	47,806.3	4.0%	9,185.2	0.4%
Хот байгуулалт, дэд бүтэц		276,227.3	33.9%	543,519.3	48.5%	614,205.8	51.5%	1,430,848.4	65.2%
Байгаль орчин, Ногоон хөгжил		140,189.7	17.2%	182,498.1	16.3%	118,228.4	9.9%	486,496.0	22.2%
Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого		374,796.5	45.9%	332,921.3	29.7%	254,669.5	21.4%	244,286.7	11.1%
Засаглал		16,317.8	2.0%	32,579.0	2.9%	100,589.7	8.4%	16,813.7	0.8%
Нийт		815,935.4	100%	1,120,752.9	100%	1,191,514.7	100%	2,193,243.8	100%

Дүгнэлт: Зорилт, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө салбарын онцлог болон хэрэгцээ, үр ашгаар эрэмбэлээгүй байна.

2.2. Төсвийн гүйцэтгэл үр дүнтэй байна уу?

Бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн 45,503.1 сая төгрөгийн гүйцэтгэлээр хөтөлбөрийн хэрэгжилт 70-80%-ийн үр дүнтэй хэрэгжиж байна.

2.2.1. Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан уу?

НЗДТГ-ын СТСХ-ээс 2019-2020 оны нийслэлийн төсөвт хүнсний аюулгүй байдлын талаар тусгайлан батлагдсан төсөл, хөтөлбөр байхгүй, гүйцэтгэл гараагүй тайлбарыг ирүүлсэн.

НХХААГ, УБЗАА-ны ХҮХҮХ-үүд нь жил бүрийн төсвийн төсөлд хөтөлбөрт суурилсан ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөн санал хүргүүлдэг боловч НИТХ баталдаггүй тул өөрсдийн үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд бусад эх үүсвэрийн 45,503.1 сая төгрөгийн санхүүжилтээр хөтөлбөрийг 70-80%-тай хэрэгжүүлэн ажиллажээ.

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн

Хүснэгт № 6 Хөтөлбөрт суурилсан ТАХ-г хэрэгжүүлэхэд авсан эх үүсвэр
/сая.төг/

№	Он	Нийслэлийн төсөв	НЗД-н Нөөц хөрөнгө	Орон нутгийн төсвийн хөрөнгө	Улсын төсөв	Төр хувийн хэвшлийн түншлэл	ОУ-н төсөл хөтөлбөр	Дүүргүүдийн ЗДТГ-с
НХХААГ	2018	2.1	1,109.0	0.8	401.4	30,000.0	0.4	
	2019	5.3	19.0	0.8	1,054.7	5,039.4	37.2	
	2020	10.0	11.0	-	162.1	5,099.0	2,136.0	
УБЗАА-ны ХҮХҮХ	2018	10.0	-	-	-	14.0	43.6	-
	2019	10.5	-	-	-	10.0		0.9
	2020	6.0	-	-	-	-		80.9
Нийт		282.9	1,139.0	1.6	1,618.2	40,162.4	2,217.2	81.8

Сүүлийн 3 жилийн байдлаар нийслэлийн төсвийн төсөлд УБЗАА-ны ХҮХҮХ-с 842.0 сая төгрөгийн, НХХААГ нь 1,068,429.5 сая төгрөгийн хөтөлбөр хэрэгжүүлэх төсөв, НМХГ нь Төв Лабораторийн барилгын шинэчлэл, шаардлагатай тоног төхөөрөмжийн зардалд зарцуулагдах 12,733.3 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлэхээр төсвийн төсөлд саналаа хүргүүлсэн байна.

Хүснэгт №7 Нийслэлийн төсвөөс олгосон санхүүжилт

№	2018 он		2019 он		2020 он	
	Төсвийн төсөлд тусгасан санал	Олгогдсон төсөв	Төсвийн төсөлд тусгасан санал	Олгогдсон төсөв	Төсвийн төсөлд тусгасан санал	Олгогдсон төсөв
НМХГ	-	-	12,620.0	-	12,733.3	-
НХХААГ	13,075.0	2.1	176,271.5	5.3	879,083.0	10.0
НЗАА	206.0	10.0	403.0	10.5	233.0	6.0
Нийт	13,281.0	12.1	189,294.5	15.8	892,049.3	16.0

Гэвч 2018-2020 онуудад 1,094,624.8 сая төгрөгийн санхүүжилтийн санал өгснөөс 0,01% хүрэхгүй буюу дөнгөж 43.9 сая төгрөг шийдвэрлэсэн нь туйлын хангалтгүй байна.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулжээ.

2.2.2. Төсвийн гүйцэтгэлд тавих хяналт үр дүнтэй байна уу?

2018-2021 онуудад бусад эх үүсвэрийн 45,503.1 сая төгрөгийн гүйцэтгэлд санхүүжүүлэгч байгууллага болох хувийн хэвшил болон ОУ-ын төсөл хөтөлбөрийн зүгээс гүйцэтгэлийн үр дүнг гэрээний үүргийг хангуулагч талд тайлагнаж баталгаажуулжээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, зорилтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаа нь нэгдсэн удирдлага, зохицуулалтгүй байна.
2. Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтад тавих хяналтын үр нөлөө багатай, хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн тогтолцоо муу, бүртгэл зөрүүтэйгээс эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хүртээмжтэй, баталгаатай хангагдах нөхцөл бүрдээгүй байна.
3. Нийслэлийн хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг зорилт чиглэлээр төлөвлөдөг боловч санхүүжилт батлагддаггүй нь хөтөлбөрийн үр дүнг бууруулж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-т

1. Нийслэлд баримтлах хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, зорилтыг нэн тэргүүнд эрэмбэлэх, төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналтын асуудлыг нэгдсэн удирдлагаар хангах;
2. Нийслэлд болзошгүй үед хэрэгжүүлэх хүнсний нөөцийн сэлгэлт, хадгалалт, хамгаалалт, санхүүжилтийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, нэгжийн үйл ажиллагааг сайжруулах;
3. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны уялдааг сайжруулах, эрүүл, аюулгүй, чанартай хүнсээр хангагдах нөхцөл боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авах.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Л.Эрдэнэчулуун/-д

1. Хүн амын хүнсний хэрэглээг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах, борлуулах, хүргэх бүх үе шатанд хяналтыг тэгш хүртээмжтэй, тогтмол хэрэгжүүлэх;
2. Илэрсэн зөрчлийг арилгах, давтан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж, хяналт шалгалтын үр нөлөөг тооцож, үр дүнг олон нийтэд таниулах.

Холбогдох байгууллагын санал


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр, 15170
Утас: 7777-5000, Факс: 7777-5120
E-mail: ub_info@inspection.gov.mn
http://www.ub.inspection.gov.mn

2021.11.03 № 01/1356
танай 2021.10.27-ны № 1070 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

Танай байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлийн аудитын
тайлантай танилцлаа. Тус газрын удирдлага, тамга,
чиглэлийн хэлтсүүдээс тухайлсан саналгүй болно.

ДАРГА



М.ЭРДЭНЭЧУЛУУН



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
Хангадий ордон, Ц.Жигжиджавын гудамж-9,
Багаторуу-3, 1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 15160
Утас: 7014-0423, 7014-0424
E-mail: info@hhaag.ub.gov.mn
http://www.hhaag.ub.gov.mn

2021.11.03 № 1/188
танай 2021.10.27-ны № 1071 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн
тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д
хийсэн аудитын /НАГ-2021/14-1-ШТА-ГА/ тайлангийн
төсөлтэй танилцлаа. Тайланд тусгах санал байхгүй
болно.

 Нийслэлийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн Газар
Удирдлага
Дарга
Даваахүү Баянбат
2021.11.03 14:04

 Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газар
Дарга
Люба Эрдэнэчулуун
2021.11.03 15:35

100085

Саналд өгсөн тайлбар

НМХГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 02-01/3562 дугаар албан бичгээр тус газрын удирдлага, тамга, чиглэлийн хэлтсүүд тусгайлсан саналгүй байгааг илэрхийлсэн.

НХХААГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 1/188 дугаар албан бичгээр аудитын тайлангийн төсөлд тусгах саналгүй байгааг илэрхийлсэн.